



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/197

Булган сум

Үр түүх байнгын болон түр талбай байгуулж
арчлалт хийх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах төсөл арга хэмжээний 32,361,000 (гучин хоёр сая гурван зуун жаран нэгэн мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хутаг-Өндөр, Булган сум, Хялганат тосгоны ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах ажлыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-тай гэрээ байгуулж, хавсралтад тусгагдсан арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг сум дундын Ойн ангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний "Сум дундын ойн ангиуд үр түүх байнгын болон түр талбай байгуулж арчлах (30га)" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.Гэрээ байгуулах эрх олгосон арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010294

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар
сарын 28-ны ний өдрийн 1/197 дугаар
захирамжийн хавсралт

Үр түүх байнгын болон түр талбай байгуулж
арчлалт хийх зардлын хуваарилалт

№	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг (төг)	Ойн ангийн даргын нэр
1	Булган сум дундын Ойн анги	10,787,000	Б.Алтансүх
2	Хялганат сум дундын Ойн анги	10,787,000	М.Нямжаргал
3	Хутаг-Өндөр сум дундын Ойн анги	10,787,000	Ш.Даваахүү
Нийт		32,361,000	